

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР



ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР
ДҮН

Аудитын код: ДА-2026/03/ҮА

СЭЛЭНГЭ АЙМАГ
2026 ОН

АГУУЛГА

№	Бүлэг, дэд бүлгийн нэр	Хуудас
	Товчилсон үгийн жагсаалт	3
	Хүснэгтийн товъёг	3
1	Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2	Аудит хийсэн байгууллагын ерөнхий мэдээлэл	5
3	Аудитын үр дүн	6
3.1	Шийдвэрийн төсөлд хийсэн эрх зүйн хяналтын хэрэгжилт	6
3.2	Худалдан авалт, хамтын ажиллагааны гэрээний хяналт	8
3.3	Шүүхэд төлөөлөх, өмгөөлөх үйл ажиллагаа	10
3.4	Эрх зүйн сургалт, сурталчилгаа	11
3.5	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	13
4	Аудитаар илрүүлсэн асуудал, зөрчил	14
5	Аудитын нэгдсэн дүгнэлт	17
6	Зөвлөмж	18

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ДАМПОУС	Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХЭЗХ	Хууль, эрх зүйн хэлтэс
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ДА	Дотоод аудит
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
БОНХОБТХ	Бүс, орон нутгийн бодлого, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төлөвлөлтийн хэлтэс
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
КРІ	Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлт (Key Performance Indicator)
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

№	Хүснэгтийн нэр	Хуудас
Хүснэгт 1	2024-2025 онд хянасан захирамж, тушаал, гэрээний төслийн динамик	6
Хүснэгт 2	Хууль, эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан сонсох ажиллагаа	7
Хүснэгт 3	Гэрээний хэрэгжилт хангагдаагүй 15 төсөл, арга хэмжээний мэдээлэл	9
Хүснэгт 4	Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээлэл (2024-2025)	10
Хүснэгт 5	Хууль тогтоомжийн системчлэл, сургалт, сурталчилгааны үзүүлэлт (2024-2025)	12
Хүснэгт 6	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт (2024-2025)	13

НЭГ. АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, 69 дүгээр зүйлийн 69.1, Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 8 дугаар зүйлийн 8.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм", Сэлэнгэ аймгийн Дотоод аудитын хорооны 2026 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан Дотоод аудитын 2026 оны төлөвлөгөө, хуваарь.
Аудитын зорилт	Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн (цаашид "ХЭЗХ" гэх) 2024-2025 оны үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээний чанар, төсвийн үр ашигтай байдлыг дээшлүүлж буй эсэхэд үнэлгээ өгөх, эрсдэлийг илрүүлэх, дотоод хяналт, засаглал, эрсдэлийн удирдлагыг сайжруулах зөвлөмж боловсруулах замаар удирдлагыг бодит мэдээллээр хангахад оршино.
Аудитын хамрах хүрээ	Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх үйл ажиллагаа, түүнтэй холбоотой баримт, мэдээллийг хамруулав.
Аудитын арга зүй	Аудитыг Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт (ДАМПОУС), Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар баталсан "Улсын салбарын дотоод аудитын аргачлал"-ын дагуу гүйцэтгэв. Гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан баримтын шалгалт, харьцуулсан дүн шинжилгээ, түүвэр шалгалт, ярилцлага, асуулга, статистик мэдээллийн боловсруулалт, бодлогын хэрэгжилтийн үнэлгээ, эрсдэлд суурилсан үнэлгээний аргуудыг хослуулан хэрэглэв.
Аудитын шалгуур үзүүлэлт	Авлигын эсрэг хууль; Гамшгаас хамгаалах тухай хууль; Гэр бүлийн тухай хууль; Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль; Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль; Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль; Зөвшөөрлийн тухай хууль; Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль; Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль; Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль; Төрийн албаны тухай хууль; Төсвийн тухай хууль; Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль; Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль; Хүүхдийн эрхийн тухай хууль; Хүүхэд хамгааллын тухай хууль; Захиргааны ерөнхий хууль; Эрүүл мэндийн тухай хууль болон эдгээртэй холбогдон гарсан Засгийн газрын тогтоол, журам.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын Санхүүгийн хяналт шалгалтын мэргэжилтэн Б.Идэрчулуун аудитыг 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд гүйцэтгэв.
Тайлангийн хэрэглэгч	Сэлэнгэ аймгийн Засаг дарга, Дотоод аудитын хороо, Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын дарга, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, ажилтнууд.

ХОЁР. АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэхүү аудитыг Сэлэнгэ аймгийн Засаг даргын баталсан 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн удирдамж, Дотоод аудитын жилийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэв.

Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс нь нутгийн захиргааны байгууллагуудын эрх зүйн актын хууль зүйн үндэслэлийг хангуулах, аймгийн Засаг дарга болон ЗДТГ-ыг шүүх, хууль хяналтын байгууллагатай харилцан ажиллахад мэргэжил, арга зүйн дэмжлэгээр хангах, хууль тогтоомжийн системчлэл, мэдээллийн сан хөтлөх, эрх зүйн сургалт, сурталчилгаа зохион байгуулах, иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх, хүний эрхийг хангах бодлогын хэрэгжилтийг хангуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Хэлтсийн бүтэц, орон тооны өөрчлөлт

Хууль, эрх зүйн хэлтсийн бүтэц, орон тооны байдал нь сүүлийн гурван жилийн хугацаанд тогтворгүй байж, дараах байдлаар өөрчлөгдсөн байна:

- 2024 онд: Аймгийн Засаг даргын захирамж, ЗДТГ-ын даргын тушаалаар 4 орон тоотой батлагдсан;
- 2025 онд: Бүтэц, орон тооны шинэчлэлийн хүрээнд "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх" чиг үүрэг бүхий 1 орон тоо нэмэгдэж, нийт 5 орон тоотой болсон;
- 2026 онд: Уг нэмэгдсэн орон тоог хасаж, хэлтсийн бүтэц дахин 4 орон тоотой болсон.

Орон тооны давтагдсан өөрчлөлт нь хэлтсийн чиг үүргийн тогтвортой хэрэгжилт, мэдлэг, туршлагын залгамж чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэл үүсгэж буйг анхаарууштай.

ГУРАВ. АУДИТЫН ҮР ДҮН

3.1. Шийдвэрийн төсөлд хийсэн эрх зүйн хяналтын хэрэгжилт

Аймгийн хэмжээнд 2024-2025 онд гарсан Засаг даргын захирамж, ЗДТГ-ын даргын тушаал, гэрээний төслүүдэд хууль зүйн хяналтыг тогтмол хийж, хууль тогтоомжид нийцүүлэх тогтолцоо бүрдсэн байна. Хяналтын тоон үзүүлэлт өссөн боловч хяналтын хамрах хүрээ зарим чиглэлээр буурсан, тухайлбал гэрээний төсөлд хийх хяналт буурсан нь эрсдэлтэй чиглэлд хяналтын идэвх суларсан байгааг харуулж байна.

Хүснэгт 1. 2024-2025 онд хянасан захирамж, тушаал, гэрээний төслийн динамик

Үзүүлэлт	2024 он	2025 он	Өсөлт/Бууралт
Захирамж	587	635 (А-590, Б-45)	↑ 8.2%
Тушаал	121	194 (А-87, Б-107)	↑ 60.3%
Гэрээ	45	29 (21 + 8 санамж бичиг)	↓ 35.6%

Үзүүлэлт	2024 он	2025 он	Өсөлт/Бууралт
Хяналтын хэлбэр	Төсөл тус бүрд дүгнэлт (753)	Нийцлийн + бодлогын зөвлөгөө (858)	↑ 13.9%

2024 онд хянасан 587 захирамж, 121 тушаалын тоо 2025 онд тус бүр 635, 194 болж өссөн боловч гэрээний төсөлд хийсэн хяналт 45-аас 29 болж 35.6 хувиар буурчээ. Хяналтын хамрах хүрээ ийнхүү буурах нь эрсдэлийн өндөртэй гэрээний хэрэгжилтэд тавих эрх зүйн хяналт суларсан байгааг илтгэж буй гол шинж тэмдэг юм.

Хууль зүйн хэлтсээс өгсөн саналын дагуу засвар, өөрчлөлт хийгдсэн буюу татгалзсан шийдвэр 2024-2025 онд гараагүй гэсэн мэдээлэл нь хяналтын чанарын талаар нэмэлт асуулт үүсгэж байна. Учир нь шийдвэрийн төслийн чанар, нийцлийн талаар тоон үзүүлэлт цуглуулсан боловч санал, дүгнэлтийн хэрэгжилтийн талаар чанарын үнэлгээний механизм бүрдээгүй байна.

Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагааны хэрэгжилт

Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлийн дагуу захиргааны шийдвэр гаргахдаа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй оролцогчдод сонсох ажиллагаа явуулсан байна. 2024 онд ХЭЗХ нь 1 удаагийн сонсох ажиллагаа зохион байгуулсан бөгөөд Бүс, орон нутгийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн саналаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сунгахтай холбоотойгоор 1 аж ахуйн нэгжид зохион байгуулсан байна. 2025 онд ХЭЗХ нь 4, бусад хэлтсүүд 10, нийт 14 сонсох ажиллагааг хууль тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулсан нь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хууль зүйн зохистой үйл ажиллагаа эрчимжсэнийг харуулж байна.

Хүснэгт 2. Хууль, эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан сонсох ажиллагаа (2024-2025 он)

№	Он	Сонсох ажиллагааны товч агуулга	Хуулийн үндэслэл	Шийдвэр
1	2024	Алтанбулаг сумын иргэн Ц.Болормаа, Отгонбаатар нарт холбогдох Алтанбулаг сумын халаалтын төвийн үйл ажиллагаатай холбоотой	Захиргааны ерөнхий хуулийн 27.4.3	Хурлын тэмдэглэлээр зохион байгуулсан
2	2025	Мандал сумын Засаг дарга Д.Хадбаатарт холбогдох сонсох ажиллагаа: Төрийн албаны тухай хуулийн 31.1, 31.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийг зөрчсөн, аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний 3.1.7, 3.1.8 дахь заалтын хэрэгжилт	Төрийн албаны тухай хуулийн 31.1, 31.2; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1; Худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйл	01/1505 (2025.11.28); 01/1555 (2025.12.08); 01/1393 (2025.12.12); 01/1411 (2025.12.15)

Сумдын ИТХ-ын шийдвэрт хийсэн хяналт-шинжилгээний хүрээнд 2025 оны Улсын үзлэгийн ажлын хүрээнд 17 сум, 6 тосгоны нийт 204 байгууллагын шийдвэрт иж бүрэн хяналт тавьж, арга зүйн зөвлөгөө өгсөн нь нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн актын чанарыг сайжруулахад тодорхой үр дүн өгсөн байна.

3.2. Худалдан авалт, хамтын ажиллагааны гэрээний төсөлд хяналт тавьсан байдал

Хууль, эрх зүйн хэлтэс нь ажил гүйцэтгэх, сургалтын болон хөдөлмөрийн гэрээнүүдийг хянан баталгаажуулж, нэгдсэн бүртгэл хөтөлсөн байна. Гэвч аймгийн ЗДТГ-аас аж ахуйн нэгжүүдтэй байгуулдаг хөрөнгө оруулалтын гэрээг ХЭЗХ урьдчилан хянадаггүй, харин Бүс, орон нутгийн бодлого, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төлөвлөлтийн хэлтсийн (БОНХОБТХ) мэргэжилтэн байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байгаа нь ажиглагдлаа.

Хууль, эрх зүйн хэлтэс нь хөрөнгө оруулалтын гэрээний нөхцөл, хариуцлагын зохицуулалтын хууль зүйн үндэслэлийг хангах чиг үүрэгтэй боловч уг гэрээнүүдийн зүйл, заалтын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьдаггүй, БОНХОБТХ-тэй хамтын ажиллагаа, уялдаа холбоо хангалтгүй байснаас хугацаа хэтэрсэн аж ахуйн нэгжүүдэд хууль зүйн арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлээгүй, нэр бүхий 15 аж ахуйн нэгжийн гэрээний хэрэгжилт тасалдсан байна. Үүнтэй холбоотойгоор төсөвт өртөг нэмэгдэх, төсвийн хөрөнгийн үр ашиг буурах, барилга байгууламж хугацаандаа ашиглалтад орохгүй байх, төрийн ашиг сонирхол хохирох эрсдэл үүсэв.

Хөрөнгө оруулалтын гэрээний үүргээ биелүүлээгүй 15 аж ахуйн нэгжийн нэгийг (Ган хөлөг констракшн ХХК) шүүхэд нэхэмжлэл гарган, 44.0 сая төгрөгийн алдангийг төлүүлэх эвлэрлийн гэрээ байгуулахаар товлосон. Үлдсэн 14 аж ахуйн нэгжийн материалыг 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр харьяа Мандал, Сайхан сумын сум дундын прокурорын газарт төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн оролцох прокурорыг томилуулахаар албан тоотоор хүргүүлсэн боловч хариу ирээгүй буюу татгалзсан байна.

Хүснэгт 3. Гэрээний хэрэгжилт хангагдаагүй 15 төсөл, арга хэмжээний мэдээлэл (сая төгрөгөөр)

№	Он	Нийт		УТХО				ОНХС			
		Тоо	Дүн	Тоо	Гэрээний дүн	Гүйц-л %	Нэх-сэн дүн	Тоо	Гэрээний дүн	Гүйц-л %	Нэх-сэн дүн
1	2016	1	114.1	-	-	-	-	1	114.1	80	97.0
2	2020	8	2,282.1	5	1,991.0	72	832.8	3	291.1	80	198.1
3	2023	1	269.3	-	-	-	-	1	269.3	40	134.6
4	Бусад	5	473.5	2	334.9	70	222.2	3	138.6	83.3	106.6
Дүн		15	3,139.0	7	2,325.9	дундаж 71	1,055.0	8	813.1	дундаж 70.8	536.4

Хүснэгтээс үзэхэд 2016-2023 онд гэрээ байгуулсан 15 төсөл, арга хэмжээний нийт 3,139.0 сая төгрөгийн гэрээний хэрэгжилт хангалтгүй байна. Үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтын 7 төсөлд 2,325.9 сая төгрөг, ОНХС-ийн 8 төсөлд 813.1 сая төгрөгийн гэрээ хамаарч байна. Гүйцэтгэлийн дундаж түвшин 70 орчим хувьд хүрсэн боловч аж ахуйн нэгжүүд гэрээнд заасан хугацаандаа ажил гүйцэтгэлийг бүрэн дуусгаагүй, нэхэмжилсэн нийт дүн 1,591.4 сая төгрөгт хүрсэн нь төрийн хохирол бий болгох эрсдэлийг тодорхой харуулж байна. Гэрээний хэрэгжилтэд тавих хяналт, хариуцлагын тогтолцоо сулраагаас хугацаа хэтэрсэн аж ахуйн нэгжүүдэд хуульд нийцсэн арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлээгүйтэй холбоотой ажээ.

3.3. Шүүхэд төлөөлөх, өмгөөлөх үйл ажиллагаа

Хууль, эрх зүйн хэлтэс нь иргэний хэрэгт нэхэмжлэгчээр, захиргааны хэрэгт ихэвчлэн хариуцагчаар оролцож, аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын даргыг итгэмжлэлээр төлөөлөн ажилладаг. Шүүхийн бүх шатны ажиллагаанд төрийн ашиг сонирхлыг хууль зүйн дагуу хамгаалж, нотлох баримт цуглуулан оролцсон байна. Тухайлбал, 2024-2025 онд аймгийн Засаг даргын захирамжийг хүчингүй болгох нэхэмжлэлтэй захиргааны хэргийн ажиллагаанд хариуцагч талыг төлөөлөн оролцоход шүүхийн шийдвэр байгууллагын талд гарсан байна.

Хүснэгт 4. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээлэл (2024-2025 он)

№	Он	Нийт хэрэг	Захиргааны хэрэг				Иргэний хэрэг			
			Нийт	Шийдвэрлэсэн	Шатандаа	Түтгэлзсэн	Нийт	Шийдвэрлэсэн	Шатандаа	Түтгэлзсэн
1	2024	3	3	3	-	-	-	-	-	-
2	2025	14	9	5	1	3	5	4	1	-

Прокурорын байгууллагатай хамтран ажилласан байдал

Сэлэнгэ аймгийн Прокурорын газар 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дугаартай тогтоолоор аймгийн ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 02/1812 дугаартай "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцуулах" хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан байна. Татгалзсан үндэслэл нь дараах байдлаар тогтоогдов:

- "ТЭТҮ" ХХК-тай 2016 оны 06 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан "Ерөө сумын хөл бөмбөгийн талбай барих" гэрээний ажил 2016 оны 08 дугаар сарын 09-ний өдөр дуусах нөхцөлтэй байсан бөгөөд Иргэний хуулийн 75.2.2-т заасан хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэж үзсэн;
- "Сүх Ундрага" ХХК-тай Шаамар сумын Дулаанхаан тосгонд наадмын талбай барих 57,159,325 төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн гүйцэтгэлийн баримтаар ажлын явц 80 хувьтай гэж тодорхойлсон, тосгоны захирагчийн 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн албан бичгээр санхүүжилт олгох тухай саналыг үндэслэлтэй гэж үзсэн;

3. "Монгол Туургатны зам" ХХК-тай Жавхлант суманд хатуу хучилттай зам барих 269,286,200 төгрөгийн гэрээ байгуулж, гэрээний нөхцөлийн дагуу ажлын 40 хувийн гүйцэтгэлд хүрсэн тохиолдолд санхүүжилт олгохоор тусгасан бөгөөд 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн албан бичиг, төлбөрийн хүсэлтийг үндэслэн 107,714,480 төгрөгийн санхүүжилтийг хууль ёсны дагуу олгосон гэж дүгнэсэн.

Прокурорын байгууллагаас дээрх компаниудын гэрээний гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжилтийг авсан, гэрээнд зааснаас илүү санхүүжилт авсан байдал баримтаар тогтоогдоогүй, төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлын хэмжээ болон нэхэмжлэлийн шаардлага тодорхойгүй гэж дүгнэсэн байна. Иймд Монгол Улсын Прокурорын тухай хуулийн 32.1 дэх хэсгийг үндэслэн прокурорын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хүсэлтийг хүлээн авахаас татгалзав. Үлдсэн 12 ААНБ-ын материалыг 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Сайхан, Мандал сумын прокурорын газарт хүргүүлсэн боловч хариу ирээгүй байна.

Энэхүү байдлаас үзэхэд гэрээний хэрэгжилтийн хяналтыг гэрээний эхэн үеэс эхлүүлэх, нотлох баримтыг бүрдүүлэх, хохирлын хэмжээг тооцох ажиллагаа цаг алдалгүй явагдах нь зөвхөн шүүхийн шатанд төрийн ашиг сонирхлыг хамгаалах боломжийг бий болгоно гэдэг нь тогтоогдов.

3.4. Эрх зүйн сургалт, сурталчилгаа, зөвлөгөө

Хууль, эрх зүйн хэлтсийн хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл, эрх зүйн сургалт, сурталчилгааны чиг үүргийн хэрэгжилтийг авч үзэхэд 2024 онд хууль тогтоомжийн бүртгэл, мэдээллийн сангийн шинэчлэл, эрх зүйн мэдээллээр иргэн, байгууллагыг хангах, сургалт, сурталчилгаа зохион байгуулах чиглэлээр тодорхой ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, хууль тогтоомжийн бүртгэл, лавламжийн санд 16,700 эрх зүйн акт бүртгэгдсэн, 37 эрх зүйн актыг шинэчлэн баяжуулсан, 44 хууль тогтоомжийг системчилсэн, эрх зүйн мэдээллийн нэгдсэн системээр 62 байгууллагад мэдээлэл хүргэсэн нь мэдээллийн хүртээмжийг хангах чиг үүргийг хэрэгжүүлсэн үзүүлэлт болж байна.

2025 оны хууль сурталчлах, эрх зүйн боловсрол олгох чиглэлээр төлөвлөгөөт болон нөлөөллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна. Тухайлбал, аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан төлөвлөгөөний дагуу 17 сум, 29 байгууллагын 972 албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад хамруулсан бөгөөд оны нийт дүнгээр бүх шатны байгууллагаас 287 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 17,719 иргэн, албан хаагчийг хамруулсан байна.

Монголын Хуульчдын холбоотой хамтран "ПРО БОНО-2025" арга хэмжээг зохион байгуулж, 12 байгууллагын оролцоотойгоор 277 иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө үзүүлсэн байна. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай болон Баялгийн сангийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт 400 гаруй иргэн, албан хаагчийн саналыг авч оролцоог хангаж ажилласан байна.

Түүнчлэн "Нэгдүгээр хүүхэд", "Бидний үнэт зүйл - хүний эрх" зэрэг видео контентыг бэлтгэн цахим орчинд түгээж, эрх зүйн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлсэн байна. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 34 удаагийн сургалт зохион байгуулж, 8,135 иргэнийг хамруулсан бөгөөд үүний үр дүнд

гэр бүлийн хүчирхийллийн зөрчил өмнөх оноос 18.4 хувиар буурсан нь сургалтын тодорхой үр нөлөө гарч байгааг харуулж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр "Drive safe - Drowsy alert" аппликейшнийг нэвтрүүлж, жолооч нарыг амраах зохицуулалт хийснээр тухайн бүсэд зам тээврийн осол бүртгэгдээгүй нь урьдчилан сэргийлэх арга хэмжээний бодит үр дүн гарсныг илтгэж байна.

Хүснэгт 5. Хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл, эрх зүйн сургалт, сурталчилгааны үзүүлэлт (2024-2025 он)

№	Ажлын чиглэл	Үзүүлэлт	2024 он	2025 он
1	Хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл	Бүртгэл, лавламжийн санд бүртгэгдсэн эрх зүйн актын тоо	16,700	16,700
		Шинээр баяжуулсан эрх зүйн актын тоо	37	42
		Системчлэл хийсэн хууль тогтоомжийн тоо	44	10
		Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системээр лавлагаа өгсөн иргэн	—	23
		Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системээр лавлагаа өгсөн байгууллага	62	25
		Бүртгэл, лавламжийн гар сангаас лавлагаа өгсөн иргэн	91	25
		Бүртгэл, лавламжийн гар сангаас лавлагаа өгсөн байгууллага	15	3
2	Аймаг, сумын Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянах	Хянаж санал өгсөн захирамжийн тоо	585	290
		Үүнээс захиргааны хэм хэмжээ тогтоосон захирамж (Хууль зүйн яаманд бүртгүүлсэн)	1	3
		Хууль зүйн яамнаас дүгнэлт гаргаж буцаасан тоо	—	—
3	Эрх зүйн сургалт, сурталчилгаа	Зохион байгуулсан эрх зүйн сургалт, хэлэлцүүлгийн тоо (төлөвлөгөөт)	290	23
		Сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан хүний тоо	9,390	17,719
		Зохион байгуулсан эрх зүйн сурталчилгааны тоо	68	36
		Боловсруулсан гарын авлага, материалын тоо	8	5
		Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан тоо	32	36

Хүснэгтээс үзэхэд эрх зүйн сургалтад хамрагдсан иргэдийн тоо 2024 онд 9,390 байсан бол 2025 онд 17,719 болж 88.7 хувиар өссөн нь эерэг чиг хандлага юм.

Гэвч сургалт, мэдээллийн ажил нь зөвхөн тоон үзүүлэлтэд тулгуурласан, сургалт, сурталчилгааны үр нөлөө, чанар, иргэдийн эрх зүйн мэдлэг, хандлагад гарсан өөрчлөлтийг үнэлсэн судалгаа, дүгнэлт хангалтгүй байна. Системчилсэн хууль тогтоомжийн хэрэгжилт, мэдээллийн сангийн ашиглалтын үр дүн, иргэдийн сэтгэл ханамжийг хэмжсэн чанарын үзүүлэлт тодорхойгүй байгаа нь гүйцэтгэлийн бодит үр дүнг үнэлэх боломжийг хязгаарлаж байна. Иймд хяналт-шинжилгээ, үнэлгээний (ХШҮ) хэлтсийн чиг үүрэгтэй уялдуулан үйл ажиллагааны үр нөлөөг хэмжих чанарын шалгуур үзүүлэлт, ХШҮ-ний тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.

3.5. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

2024 оны жилийн эцсийн байдлаар Сэлэнгэ аймгийн хэмжээнд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд нийт 4,555 санал, хүсэлт, өргөдөл, гомдол ирүүлснээс 4,377-г шийдвэрлэж, 96.1 хувийн шийдвэрлэлтийн үзүүлэлттэй ажилласан байна. Аймгийн ЗДТГ-ын шийдвэрлэлтийн хувь 99.3, агентлаг байгууллагуудынх 98.3 хувь байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлттэй байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд нийт 3,949 өргөдөл, гомдол ирүүлснээс 3,803-г шийдвэрлэж, 96.3 хувийн шийдвэрлэлтийн үзүүлэлттэй ажилласан байна. Өмнөх онтой харьцуулахад нийт өргөдөл, гомдлын тоо буурсан боловч шийдвэрлэлтийн түвшин тогтвортой хадгалагдсан нь өргөдөл, гомдлыг шийдвэрлэх үйл ажиллагаа хэвийн хэрэгжиж байгааг харуулж байна.

Хүснэгт 6. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт (2024-2025 он)

Үзүүлэлт	2024 он	2025 он	Өөрчлөлт
Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо	4,555	3,949	↓ 13.3%
Шийдвэрлэгдсэн тоо	4,377	3,803	↓ 13.1%
Шийдвэрлэлтийн хувь	96.1%	96.3%	↑ 0.2 пп
ЗДТГ-ын шийдвэрлэлтийн хувь	99.3%	—	—
Агентлаг байгууллагын шийдвэрлэлтийн хувь	98.3%	—	—

2025 онд иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах сувгийг өргөжүүлж, 7036-1111 тусгай дугаар, цахим хуудас, 11-11 төвөөр дамжуулан хүлээн авах боломжийг бүрдүүлсэн бөгөөд иргэдийг тогтмол хүлээн авах өдөртэй болсон нь төрийн үйлчилгээний хүртээмж, шуурхай байдлыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа болсон байна.

Өргөдөл, гомдлын агуулгын хувьд ажилд орох хүсэлт, газрын харилцаа, санхүүгийн дэмжлэг, төрийн үйлчилгээтэй холбоотой асуудлууд давамгайлсан хэвээр байна. Нийт дүнгээр өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тогтолцоо тогтвортой хэрэгжиж, иргэдэд хүрэх сувгийг нэмэгдүүлсэн эерэг өөрчлөлт ажиглагдсан хэдий ч давтагдсан шинжтэй газрын харилцаа, төрийн үйлчилгээ, нийгмийн хамгааллын асуудлуудад суурь шалтгааны түвшинд арга хэмжээ авч,

сумдын түвшний шийдвэрлэлтийн чанар, хугацааны хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй бүртгэгдсэн гомдол, мэдээлэлд хийсэн дүн шинжилгээний дагуу гэр бүлийн хүчирхийлэл ихээр үйлддэг нэг төрийн байгууллагыг сонгон, 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр "Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт", "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль", "Зөрчлийн тухай хууль"-ийн холбогдох заалтын хүрээнд сургалт зохион байгуулан ажилласнаар тухайн байгууллагын албан хаагчдаас давтан гэр бүлийн хүчирхийлэлд холбогдсон албан хаагч бүртгэгдээгүй байгаа нь зорилтот сургалтын үр нөлөөг харуулсан жишээ юм.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АСУУДАЛ, ЗӨРЧИЛ

Хууль, эрх зүйн хэлтсийн 2024-2025 оны үйл ажиллагаанд хийсэн аудитаар үндсэн чиг үүргийн хэрэгжилт нийтдээ хангалттай түвшинд явагдсан боловч дотоод хяналтын тогтолцоо, хөрөнгө оруулалтын гэрээний эрх зүйн хяналт, хариуцлагын механизм, сургалт сурталчилгааны үр нөлөөг хэмжих хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоонд сайжруулах шаардлагатай дөрвөн үндсэн асуудлыг илрүүлэв. Эдгээр асуудлууд нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол, ДАМПОУС-ын дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын стандартын шаардлагатай нийцэхгүй байгаа тул дараах байдлаар нэгтгэн томъёолов.

4.1. Илрүүлсэн асуудал 1: Дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын хэрэгжилт хангалтгүй байна

Асуудлын ангилал	Үндсэн (Нөлөө их)	Эрсдэлийн зэрэг	Өндөр
------------------	-------------------	-----------------	-------

Бодит байдал: Хууль, эрх зүйн хэлтсийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлоогүй, дотоод хяналтын төлөвлөгөөгүй, тайлагналын тогтолцоо бүрдээгүй, ажилтнуудын дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын талаарх мэдлэг, ойлголт хангалтгүй байна. Үүнтэй холбогдуулан анхаарал татаж буй гол зөрчлүүд:

- Үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлсон албан ёсны баримт бичиг бүрдээгүй;
- ЗДТГ-ын хэмжээнд дотоод хяналтын журам батлагдан мөрдөгдөөгүй;
- Эрсдэлийн бүртгэл, эрсдэлийн матриц, эрсдэлийн үнэлгээний тайлан гэх дотоод хяналтын суурь баримт бичиг үгүйлэгдэж байна;
- Хэлтэс өөрийн чиг үүргийн хүрээнд дотоод хяналтын ажлын тайланг тогтмол гаргаж танилцуулдаггүй.

Үүний улмаас үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг урьдчилан тодорхойлох, алдаа, зөрчил, үр ашиггүй байдлыг илрүүлэх, бодлогын хэрэгжилтийн үр дүн, гүйцэтгэлд хяналт тавих боломж хязгаарлагдсан байна.

Шалгуур (Байх ёстой шаардлага): Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл

ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.5-д "Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө" гэж заасан. Мөн журмын 3.1-д "...дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах үүргийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны асуудал хариуцсан нэгж, ажилтан гүйцэтгэнэ" гэж тогтоосон. Үүнээс гадна ДАМПОУС-ын Стандарт 2110 (Засаглал), 2120 (Эрсдэлийн удирдлага), 2130 (Хяналт)-д заасан шаардлага.

Шалтгаан: (1) Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын чиг үүргийг зөвхөн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ажил гэж буруу ойлгож, хэлтсийн дотоод соёл, өдөр тутмын үйл ажиллагааны элемент болгон хэвшүүлээгүй; (2) Хэлтсийн ажилтнуудад дотоод хяналтын стандарт, COSO загвар, эрсдэлд суурилсан аудитын аргачлалын талаарх мэргэшсэн сургалт зохион байгуулагдаагүй; (3) ЗДТГ-ын хэмжээнд дотоод хяналтын ерөнхий журам батлагдаагүйгээс хэлтсүүд өөрсдийн дэд журам, төлөвлөгөөг боловсруулах эрх зүйн үндэс бүрдээгүй.

Үр дагавар (Хэлтэс, байгууллагад үзүүлэх нөлөө): Алдаа, зөрчил давтагдах, үйл ажиллагааны үр дүн хангалтгүй болох, төсвийн хөрөнгө үрэгдэх, төрийн ашиг сонирхол хохирох, бодлогын хэрэгжилтэд хяналт тавих чадавх суларч, удирдлагын шийдвэрийн чанар буурах эрсдэлтэй.

Зөвлөмж:

1. 2026 оны II улиралд багтаан Хэлтсийн чиг үүргийн хүрээнд тулгарч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийн матриц, эрсдэлийн бүртгэл, дотоод хяналтын төлөвлөгөөг боловсруулан баталж, улирал тутмын тайлагналын механизмыг бүрдүүлэх;
2. 2026 оны III улиралд багтаан ЗДТГ-ын хэмжээнд мөрдөх "Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын журам"-ыг боловсруулах саналыг ЗДТГ-ын даргад албан ёсоор хүргүүлэх;
3. Хэлтсийн ажилтнуудад зориулсан дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын чиглэлийн дотоод сургалт, чадавх бэхжүүлэх ажлыг 2026 онд тогтмол зохион байгуулах.

4.2. Илрүүлсэн асуудал 2: Хөрөнгө оруулалтын гэрээний эрх зүйн хяналт, хариуцлагын арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна

Асуудлын ангилал	Үндсэн (Нөлөө их)	Эрсдэлийн зэрэг	Өндөр
------------------	-------------------	-----------------	-------

Бодит байдал: Хууль, эрх зүйн хэлтэс нь ажил гүйцэтгэх, сургалтын болон хөдөлмөрийн гэрээнүүдийг хянан баталгаажуулж, нэгдсэн бүртгэл хөтөлсөн боловч хөрөнгө оруулалтын гэрээг урьдчилан хянадаггүй буюу БОНХОБТХ-ийн мэргэжилтэн дангаараа байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьсан байна. ХЭЗХ нь хөрөнгө оруулалтын гэрээний нөхцөл, хариуцлагын зохицуулалтын хууль зүйн үндэслэлийг хангах чиг үүрэгтэй боловч уг гэрээний зүйл, заалтын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьдаггүй, БОНХОБТХ-тэй хамтын ажиллагаа, уялдаа холбоо хангалтгүй байснаас үүссэн зөрчлийг тухай бүр шуурхай арилгаж чадаагүй байна.

Үүний улмаас 2016-2023 онд гэрээ байгуулсан 15 аж ахуйн нэгжийн нийт 3,139.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний хэрэгжилт тасалдаж, 1,591.4 сая төгрөгийн нэхэмжлэлийн дүн бүхий эрсдэл үүсэв. Эдгээрээс зөвхөн нэг аж ахуйн нэгжтэй (Ган хөлөг констракшн ХХК) шүүхэд нэхэмжлэл гарган 44.0 сая төгрөгийн алданги төлүүлэхээр эвлэрлийн гэрээ байгуулахаар товлосон бөгөөд үлдсэн 14 аж ахуйн нэгжийн материалыг 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр сум дундын прокурорын газарт хүргүүлсэн боловч 3 аж ахуйн нэгжийн талаарх хүсэлтэд прокурор татгалзсан, бусад нь хариу ирээгүй байна.

Шалгуур (Байх ёстой шаардлага): Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2025 оны ХЭГ/754 дугаар чиглэлийн 2 дахь хэсэгт "Хууль, эрх зүйн хэлтэс нь нутгийн захиргааны байгууллагуудын эрх зүйн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хангуулж, аймгийн Засаг даргаас хууль хяналтын байгууллагатай харилцан ажиллах ... зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг" гэж заасан. Мөн "Ган хөлөг констракшн" ХХК-тай 2020 оны 7 дугаар сарын 21-ний СЭ01-101/2020 дугаартай гэрээний 46 дугаар хэсэгт "Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 10 хувь байна. ... гэрээг цуцлах үндэслэл болно" гэж тусгасан. Иргэний хуулийн 75.2.2-т заасан хөөн хэлэлцэх хугацаа, Прокурорын тухай хуулийн 32.1, Төсвийн тухай хуулийн 16, 41 дүгээр зүйл болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтуудыг үндэслэл болгон жагсаав.

Шалтгаан: (1) Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд ХЭЗХ-ээс урьдчилан хууль зүйн хяналт хийх журам, хяналтын хуудас (checklist) бүрдээгүй; (2) ХЭЗХ ба БОНХОБТХ хоорондын мэдээлэл солилцох, хамтран ажиллах журам, гэрээний хэрэгжилтийн хяналтын тогтолцоо хангалтгүй; (3) Гэрээний эрсдэлд тулгуурласан хяналт-шинжилгээ, мониторингийн механизм бүрдээгүйгээс хугацаа хэтэрсэн зөрчлийг тухай бүр илрүүлэн арга хэмжээ авах боломжгүй болсон; (4) Хохирол барагдуулах ажиллагааг хугацаа хоцорсноор хөөн хэлэлцэх хугацаа дууссан, нотлох баримтын материалыг бүрэн бүрдүүлээгүй зэргээс шалтгаалан прокурорын байгууллагаас татгалзсан хариу авах нөхцөл бүрдэв.

Үр дагавар: Гэрээний хэрэгжилт тасалдах, төсөвт өртөг нэмэгдэх, төсвийн хөрөнгийн үр ашиг буурах, барилга байгууламж, ажил, үйлчилгээ хугацаандаа ашиглалтад орохгүй байх, нэхэмжилсэн 1,591.4 сая төгрөгийн төрийн хохирол хугацаандаа барагдахгүй байх, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлөх эрсдэл үүссэн.

Зөвлөмж:

1. Хөрөнгө оруулалт, худалдан авалтын чиглэлийн гэрээний төсөл бүрд ХЭЗХ-ээс урьдчилсан хууль зүйн хяналт хийх журам, хяналтын хуудсыг боловсруулан баталгаажуулах;
2. ХЭЗХ ба БОНХОБТХ хоорондын мэдээлэл солилцох, хамтран ажиллах журам боловсруулж, гэрээний хэрэгжилтэд хамтарсан хяналт-шинжилгээ хийдэг тогтолцоог бүрдүүлэх;
3. Үүргээ биелүүлээгүй 14 аж ахуйн нэгжийн материалыг дахин нягтлан, нотлох баримтыг бүрэн бүрдүүлж, хохирлын хэмжээг тогтоосны үндсэн дээр

шүүх, прокурорын байгууллагатай идэвхтэй хамтран ажиллаж, хохирол барагдуулах ажиллагааг түргэвчлэн хэрэгжүүлэх;

- Хөөн хэлэлцэх хугацаа дуусахаас сэргийлэх зорилгоор гэрээний хяналтын мэдээллийн санг бүрдүүлж, дуусах хугацааны мэдэгдлийг автоматаар өгдөг тогтолцоог нэвтрүүлэх.

4.3. Илрүүлсэн асуудал 3: Эрх зүйн сургалт, сурталчилгааны үр нөлөөг хэмжих ХШҮ-ний тогтолцоо бүрдээгүй байна

Асуудлын ангилал	Гүйцэтгэлийн (Нөлөө дунд)	Эрсдэлийн зэрэг	Дунд
------------------	---------------------------	-----------------	------

Бодит байдал: Эрх зүйн сургалт, сурталчилгааны хүрээнд 2024 онд 290 удаагийн сургалт, 9,390 хамрагдагч; 2025 онд 287 удаагийн сургалт, 17,719 хамрагдагч (давхардсан тоогоор) гэх тоон үзүүлэлтийг бүрэн тооцсон боловч сургалтын үр нөлөө, иргэдийн эрх зүйн мэдлэг, хандлагад гарсан өөрчлөлт, мэдээллийн сангийн ашиглалтын чанар, иргэдийн сэтгэл ханамжийг хэмжсэн чанарын үзүүлэлт буюу ХШҮ-ний тогтолцоо бүрдээгүй байна. Зөвхөн гэр бүлийн хүчирхийллийн чиглэлийн сургалтын үр дүн (зөрчил 18.4 хувиар буурсан) гэх нэг тохиолдлоор үр нөлөөг тодорхойлсноос бусад сургалтын үнэлгээ хийгдээгүй.

Шалгуур: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу үйл ажиллагааны үр дүнг чанарын болон тоон шалгуур үзүүлэлтээр үнэлэх шаардлагатай. Мөн ДАМПОУС-ын Стандарт 2130 (Хяналт)-д заасан хяналтын үр нөлөөг үнэлэх шаардлага.

Шалтгаан: (1) Хэлтсийн жилийн төлөвлөгөөнд сургалт, сурталчилгааны үр нөлөөг хэмжих чанарын шалгуур үзүүлэлт (KPI) тусгагдаагүй; (2) Сургалт, мэдээллийн ажлын үр дүнг үнэлэх асуулга, судалгааны арга зүй боловсруулагдаагүй; (3) ХШҮ-ний хэлтэс, ХЭЗХ-ийн хамтын ажиллагаа сургалт, сурталчилгааны чиглэлээр уялдаа муутай байна.

Үр дагавар: Сургалт, сурталчилгааны үйл ажиллагааны бодит үр нөлөөг үнэлэх боломж хязгаарлагдсан, төсвийн зардлын үр ашгийг тооцох баримт суурь үгүйлэгдэж, бодлогын шийдвэр гаргалтад үндэслэл болох мэдээлэл хангалтгүй болох эрсдэлтэй.

Зөвлөмж:

- Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын үр нөлөөг хэмжих чанарын шалгуур үзүүлэлт (мэдлэг шалгах сорил, хандлагын өөрчлөлтийн судалгаа, иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа гэх мэт)-ийг боловсруулан мөрдөх;
- ХШҮ-ний хэлтэстэй хамтран сургалт, сурталчилгааны үр дүнгийн жилийн үнэлгээний тайланг боловсруулж, удирдлагад танилцуулдаг болох;
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн ашиглалт, иргэдийн хандалт, ашиг тусын талаарх дижитал индикаторыг тогтсон давтамжтайгаар хэмжиж тайлагнах механизмыг бүрдүүлэх.

4.4. Илрүүлсэн асуудал 4: Хэлтсийн орон тооны тогтворгүй байдал, чиг үүргийн залгамж чанарт нөлөөлж буй эрсдэл

Асуудлын ангилал	Зохион байгуулалтын (Нөлөө дунд)	Эрсдэлийн зэрэг	Дунд
------------------	----------------------------------	-----------------	------

Бодит байдал: Хэлтсийн орон тооны тоо 2024 онд 4, 2025 онд 5, 2026 онд дахин 4 болж, хоёр жилийн дотор 2 удаагийн өөрчлөлт орсон. Тухайлбал, 2025 онд нэмэгдсэн "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх" чиг үүргийн орон тоог 2026 онд хасахаар шийдвэрлэснээр уг чиг үүргийн залгамжлал, ажлын тасралтгүй байдалд эрсдэл үүсэв.

Шалгуур: Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу байгууллагын бүтэц, орон тоог үндэслэл, шинжилгээ, ажлын байрны тодорхойлолт зэргээр үндэслэн тогтоох шаардлагатай.

Шалтгаан: Орон тоо нэмэгдүүлэх, хасах шийдвэрт ажлын ачаалал, чиг үүргийн хэрэгцээ-шаардлагын дүн шинжилгээ хангалттай хийгдээгүй; чиг үүрэг буурсан үндэслэлийг тодорхой бичиг баримтаар нотолсон, харьцуулсан судалгаа хийгдээгүй байж болзошгүй.

Үр дагавар: Чиг үүргийн залгамж чанар алдагдах, мэдлэг, туршлага шилжих процесс эвдрэх, хууль зүйн орчны шинэчлэлд тохирсон чадавхын бэлтгэл хангалтгүй болох, ажилтнуудын ажлын ачаалал нэмэгдэх, төрийн үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлтэй.

Зөвлөмж:

- Хэлтсийн орон тооны өөрчлөлтийг хийхдээ ажлын ачаалал, чиг үүргийн ач холбогдол, ачааллын тооцоо, харьцуулсан судалгаа, нөлөөллийн үнэлгээг үндэслэлтэй хийж, шийдвэрийг батлахаас өмнө ХЭЗХ-ийн дарга, ХШҮ-ний хэлтсийн дүгнэлтийг авах механизмыг бүрдүүлэх;
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг үлдсэн орон тоонуудад хэрхэн хуваарилах, эсхүл өөр хэлтсэд шилжүүлэх талаар тодорхой шийдвэр гаргаж, чиг үүргийн уялдаа, тасралтгүй байдлыг хангах.

ТАВ. АУДИТЫН НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс нь 2024-2025 онд үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан бөгөөд эрх зүйн актын төсөлд хийсэн хяналт, иргэдэд үзүүлэх хууль зүйн зөвлөгөө, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр тодорхой үр дүнд хүрсэн байна. Гэвч аудитаар дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын баримт бичиг бүрдээгүй; хөрөнгө оруулалтын гэрээний эрх зүйн хяналт, хариуцлагын механизмын хэрэгжилт хангалтгүй; сургалт, сурталчилгааны үр нөлөөг хэмжих хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо боловсронгуй болоогүй; хэлтсийн орон тооны давтан өөрчлөлт чиг үүргийн залгамж чанарт нөлөөлж буй зэрэг сайжруулах шаардлагатай асуудлууд илэрсэн болно.

Иймд Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын төлөвшлийн ерөнхий түвшинг дараах байдлаар үнэлэв:

Үнэлгээний чиглэл	Түвшин	Тайлбар
Засаглалын үйл явц	3-р түвшин: Давтамжтай (тогтсон)	Чиг үүрэг, үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж явагдаж буй боловч баримтжуулалт, шийдвэрийн эргэн засуулалтын тогтолцоо хангалтгүй.
Эрсдэлийн удирдлага	2-р түвшин: Анхан (хөгжиж буй)	Эрсдэлийг тогтмол тодорхойлж бүртгэдэг, эрсдэлийн матриц, төлөвлөгөөтэй ажилладаг тогтолцоо бүрдээгүй.
Дотоод хяналт	2-р түвшин: Анхан (хөгжиж буй)	Дотоод хяналтын журам, төлөвлөгөө, тайлагнал бүрдээгүй; зарим элементүүд тасалданги хэрэгждэг.
Ерөнхий үнэлгээ	Сайжруулах шаардлагатай	Аудитаар илрүүлсэн 4 асуудлын 50 хувь нь үндсэн (нөлөө их) асуудалд хамаарч байгаа тул хэлтсийн үйл ажиллагааны төлөвшлийн ерөнхий түвшинг "Сайжруулах шаардлагатай" гэж дүгнэв.

Нэгдсэн дүгнэлт: Хэлтсийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын төлөвшлийг **"Сайжруулах шаардлагатай"** гэж дүгнэв. Илрүүлсэн дөрвөн асуудлаас хоёр нь үндсэн (нөлөө их), хоёр нь дунд зэргийн нөлөөтэй ангиллын асуудалд хамаарах бөгөөд эдгээрийг тус тус зөвлөмжийн дагуу хугацаандаа хэрэгжүүлснээр хэлтсийн үйл ажиллагааны үр дүн, төрийн үйлчилгээний чанар, төсвийн хөрөнгийн үр ашиг дээшилнэ гэж үзэв.

ЗУРГАА. НЭГТГЭСЭН ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн асуудлуудыг арилгах, хэлтсийн үйл ажиллагааны үр дүн, чанарыг сайжруулах зорилгоор Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, ЗДТГ-ын даргад дараах зөвлөмжийг хүргүүлж байна:

Хүснэгт 7. Зөвлөмжийн нэгдсэн жагсаалт, хэрэгжүүлэх хариуцагч, хугацаа

№	Зөвлөмжийн агуулга	Хариуцагч	Хэрэгжүүлэх хугацаа	Илрүүлэлт
1	Хэлтсийн чиг үүргийн хүрээнд тулгарч болзошгүй эрсдэлийн матриц, эрсдэлийн бүртгэл, дотоод хяналтын төлөвлөгөөг боловсруулан баталж, улирал тутмын тайлагналын механизмыг бүрдүүлэх.	ХЭЗХ-ийн дарга	2026 оны II улирал	4.1
2	ЗДТГ-ын хэмжээнд мөрдөх "Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын журам"-ыг боловсруулах саналыг ЗДТГ-ын даргад хүргүүлж, хамтран ажиллах.	ХЭЗХ-ийн дарга, ХШҮ-ний хэлтэс	2026 оны III улирал	4.1
3	Хөрөнгө оруулалт, худалдан авалтын чиглэлийн гэрээний төсөл бүрд ХЭЗХ-ээс урьдчилсан хууль зүйн хяналт хийх журам, хяналтын хуудсыг (checklist) баталгаажуулж мөрдөх.	ХЭЗХ-ийн дарга, БОНХОБТХ	2026 оны II улирал	4.2
4	ХЭЗХ ба БОНХОБТХ хоорондын мэдээлэл солилцох, хамтын ажиллагааны журам, гэрээний	ЗДТГ-ын дарга, ХЭЗХ-	2026 оны III улирал	4.2

№	Зөвлөмжийн агуулга	Хариуцагч	Хэрэгжүүлэх хугацаа	Илрүүлэлт
	хэрэгжилтэд хамтарсан хяналт-шинжилгээ хийдэг тогтолцоог бүрдүүлэх.	ийн дарга, БОНХОБТХ		
5	Үүргээ биелүүлээгүй 14 аж ахуйн нэгжийн материалыг дахин нягтлан, нотлох баримтыг бүрэн бүрдүүлж, шүүх, прокурорын байгууллагатай хамтран ажиллаж, хохирол барагдуулах ажиллагааг үр дүнд хүргэх.	ХЭЗХ-ийн дарга	Тогтмол (улирал тутам тайлагнах)	4.2
6	Гэрээний хяналтын мэдээллийн санг бүрдүүлж, гэрээний хугацаа, хөөн хэлэлцэх хугацааны автомат мэдэгдэл өгдөг тогтолцоог нэвтрүүлэх.	ХЭЗХ-ийн дарга, ЗДТГ-ын Мэдээлэл, технологийн нэгж	2026 оны IV улирал	4.2
7	Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын үр нөлөөг хэмжих чанарын шалгуур үзүүлэлт (мэдлэгийн сорил, хандлагын судалгаа, сэтгэл ханамжийн судалгаа)-ийг боловсруулан мөрдөх.	ХЭЗХ-ийн дарга, ХШҮ-ний хэлтэс	2026 оны III улирал	4.3
8	Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн ашиглалт, ач тус, иргэдийн хандалтын дижитал индикаторыг тогтсон давтамжтайгаар хэмжиж тайлагнах механизмыг бүрдүүлэх.	ХЭЗХ-ийн дарга	Тогтмол	4.3
9	Хэлтсийн орон тооны өөрчлөлт хийх тохиолдолд ажлын ачаалал, чиг үүргийн ач холбогдол, нөлөөллийн дүн шинжилгээний үндэслэлээр шийдвэр гаргах механизмыг бүрдүүлж, чиг үүргийн залгамж чанарыг хангах.	ЗДТГ-ын дарга, ХЭЗХ-ийн дарга	2026 оны III улирал	4.4

Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангийн хамт Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлнэ үү.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:




ДОТООД АУДИТОР

ТАЙЛАН ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА

ТАНИЛЦСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Б.ИДЭРЧУЛУУН
 Т.ОДСҮРЭН
 Б.ЯНЖИНЛХАМ